БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2023/98/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: кhuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: У.Ербол<br>Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

**АГУУЛГА**

1.**ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .......... 4
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .......... 6
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** .......... 14
**4. АУДИТЫН ТАЙЛАН** .......... 18
**4.1 Ерөнхий зүйл** .......... 18
**4.2 Материаллаг байдал** .......... 18
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** .......... 18
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 18
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** .......... 18
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** .......... 19
**4.5.1 Завсрын аудитын талаар** .......... 19
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .......... 20
**5.1 Төлбөрийн акт** .......... 20
**5.2 Албан шаардлага** .......... 20
**5.3 Зөвлөмж** .......... 20
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .......... 20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2023.02.20 № 115
танай ______ -ны № ______ -т

УЛААНХУС СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.АЙГҮЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **52,746,217.69** | **53,060,965.59** |
| **33** | **АВЛАГА** | - | 450,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 450,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 52,746,217.69 | 52,610,965.59 |
| **351** | **Түүхий эд материал** | 331,500.00 | 331,500.00 |
| 35130 | Эм боох материал | 331,500.00 | 331,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 52,414,717.69 | 52,279,465.59 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 885,000.00 | 1,259,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,459,840.00 | 15,182,176.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 610,500.00 | 610,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,694,072.76 | 757,653.76 |
| 35460 | Хүнсний материал | 13,872,222.87 | 7,576,653.77 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 26,893,082.06 | 26,893,082.06 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **499,732,183.21** | **653,571,877.04** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 499,732,183.21 | 653,571,877.04 |
| **392** | **Биет хөрөнгө** | 476,384,183.21 | 630,223,877.04 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 478,810,110.47 | 478,810,110.47 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (28,729,568.95) | (38,733,277.27) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 15,837,200.00 | 27,357,200.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (9,712,546.33) | (12,332,573.41) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,368,136.44 | 10,968,136.44 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,486,900.77) | (6,536,531.65) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 37,353,161.15 | 37,353,161.15 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (22,055,408.80) | (26,662,348.69) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | - | 160,000,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 23,348,000.00 | 23,348,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |

| | | | |
|---|---|---|---|
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 23,348,000.00 | 23,348,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **552,478,400.90** | **706,632,842.63** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **11,259,413.00** | **22,255,206.58** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 11,259,413.00 | 22,255,206.58 |
| **413** | **Өглөг** | 11,259,413.00 | 22,255,206.58 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 3,935,567.58 |
| **4136** | **Бусад өглөг** | 11,259,413.00 | 18,319,639.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 11,259,413.00 | 18,319,639.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **541,218,987.90** | **684,377,636.05** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 541,218,987.90 | 684,377,636.05 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 158,422,772.00 | 158,422,772.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 158,422,772.00 | 158,422,772.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 133,726,777.90 | 276,885,426.05 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 133,726,777.90 | 133,726,777.90 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 143,158,648.15 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 249,069,438.00 | 249,069,438.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **552,478,400.90** | **706,632,842.63** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **317,844,854.00** | **866,320,500.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **317,844,854.00** | **866,320,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 305,645,700.00 | 783,092,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 613,572,500.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | | 169,520,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 305,645,700.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 103,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 103,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 10,706,600.00 | 83,124,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 10,706,600.00 | 83,124,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 133005 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | - | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,492,554.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,492,554.00 | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **543,207,775.16** | **723,161,851.85** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **543,207,775.16** | **723,161,851.85** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 541,715,221.16 | 723,161,851.85 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 449,532,082.86 | 522,986,367.58 |
| 210101 | Үндсэн цалин | 449,532,082.86 | 426,345,135.58 |
| 210102 | Нэмэгдэл | - | 81,885,832.00 |
| 210104 | Урамшуулал | - | 14,755,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 59,819,000.00 | 64,585,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,094,900.00 | 43,918,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,431,100.00 | 5,166,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,544,800.00 | 4,133,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 886,200.00 | 1,033,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,862,000.00 | 10,333,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,210,928.00 | 29,102,645.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,873,400.00 | 1,399,300.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,337,528.00 | 27,703,345.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 593,300.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 95,300.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 44,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 454,000.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 3,593,172.00 | 78,858,069.10 |
| 210502 | Хоол, хүнс | 3,593,172.00 | 78,858,069.10 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 182,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 182,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 250,000.00 | 1,366,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 250,000.00 | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,366,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,534,738.30 | 26,263,370.17 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 5,107,464.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 2,875,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 7,534,738.30 | 18,280,306.17 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,492,554.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,492,554.00 | - |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 1,492,554.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(225,362,921.16)** | **143,158,648.15** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(225,362,921.16)** | **143,158,648.15** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **558,646,054.00** | **696,800,500.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **558,646,054.00** | **696,800,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 536,897,900.00 | 613,572,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 613,572,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 536,897,900.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 205,000.00 | 103,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 205,000.00 | 103,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 20,050,600.00 | 83,124,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,050,600.00 | 83,124,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,492,554.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,492,554.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **556,722,254.00** | **694,200,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **556,722,254.00** | **694,200,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **555,229,300.00** | **694,200,500.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 450,804,400.00 | 519,460,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 401,449,500.00 | 426,468,143.00 |
| 210102 | Нэмэгдэл | | 78,237,357.00 |
| 210104 | Урамшуулал | 32,816,600.00 | 14,755,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16,538,300.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 59,819,000.00 | 64,585,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,094,900.00 | 43,918,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,431,100.00 | 5,166,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,544,800.00 | 4,133,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 886,200.00 | 1,033,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,862,000.00 | 10,333,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,840,600.00 | 21,166,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,873,400.00 | 3,373,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,967,200.00 | 17,793,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,687,100.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 1,061,700.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,052,300.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 466,000.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | 113,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,994,100.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 16,039,100.00 | 72,562,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 733,500.00 | |
| 210502 | Хоол, хүнс | 14,189,500.00 | 72,562,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,116,100.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 210,000.00 | 300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 210,000.00 | 300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 501,800.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 501,800.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,327,300.00 | 1,406,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,077,300.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1,406,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 14,719,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 11,469,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 3,250,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,492,954.00** | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,492,554.00 | - |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 1,492,554.00 | |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 400.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 400.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,923,800.00** | **2,600,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,923,800.00** | **2,600,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,923,800.00** | **2,600,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,923,800.00 | 2,600,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,923,800.00 | 2,600,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,923,800.00)** | **(2,600,000.00)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 158,422,772.00 | 258,722,938.00 | 169,796,581.81 | | 586,942,291.81 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 9,653,500.00 | | 9,653,500.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **158,422,772.00** | **258,722,938.00** | **179,450,081.81** | **0.00** | 596,595,791.81 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | -9,653,500.00 | | | -9,653,500.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | -1,116,502.08 | | -1,116,502.08 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | | **0.00** | 0.00 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **158,422,772.00** | **249,069,438.00** | **133,726,777.90** | **0.00** | 541,218,987.90 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 0.00 | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | **0.00** | 0.00 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 158,422,772.00 | 249,069,438.00 | 133,726,777.90 | | 541,218,987.90 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 143,158,648.15 | | 143,158,648.15 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **158,422,772.00** | **249,069,438.00** | **276,885,426.05** | **0.00** | 684,377,636.05 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 696,697,000.00 | 696,697,000.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 696,697,000.00 | 696,697,000.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 696,697,000.00 | 696,697,000.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 519,460,900.00 | 519,460,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 427,724,500.00 | 426,468,143.00 |
| 210102 | Нэмэгдэл | 76,981,000.00 | 78,237,357.00 |
| 210104 | Урамшуулал | 14,755,400.00 | 14,755,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 64,585,300.00 | 64,585,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,918,100.00 | 43,918,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,166,800.00 | 5,166,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,133,400.00 | 4,133,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,033,400.00 | 1,033,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,333,600.00 | 10,333,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,166,500.00 | 21,166,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,373,400.00 | 2,158,630.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,793,100.00 | 19,007,870.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 72,562,500.00 | 72,562,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 72,562,500.00 | 72,562,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 300,000.00 | 300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 300,000.00 | 300,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,406,000.00 | 1,406,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,406,000.00 | 1,406,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,215,800.00 | 17,215,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,965,800.00 | 11,965,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,250,000.00 | 5,250,000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 696,697,000.00 | 696,697,000.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 613,572,500.00 | 613,572,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 613,572,500.00 | 613,572,500.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 83,124,500.00 | 83,124,500.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 83,124,500.00 | 83,124,500.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 49 | 49 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 20 | 20 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 26 | 26 |
| 620004 | Гэрээт ажилтан | 2 | 2 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **49** | **49** |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 26 | 26 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 23 | 23 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **103,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **103,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 103,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 103,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 103,500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 103,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 103,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 103,500.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл нь бага насны хүүхдүүдтэй сургуулийн өмнөх боловсролын эзэмшүүлэх, хүүхэд бүрийг хөгжүүлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангаан, асран хамгаалах , сургуулийн өмнөх боловсролын тухай хууль бусад холбогдох хууль дүрэм журмыг мөрдөн ажиллах.

Цэцэрлэгийн зорилгыг “хүүхэд нэг бүрийн хүсэл сонирхлыг хүндэтгэж, тэдний сурч, хөгжин төлөвших сургуулийн таатай орчин бүрдүүлж, хүүхдийн сэтгэл санааны аятай байдлыг дэмжин, сургуулийн өмнөх боловсролын чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлж хүүхдэд ээлтэй цэцэрлэг болгон хөгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүртээмжтэй болгох,
- СӨБ-ын хүүхэд хөгжих таатай орчин бүрдүүлэх,
- Сургалтын технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэх,
- СӨБ-ын боловсон хүчний мэргэжлийн чадавх дээшлүүлэх
- СӨБ-ыг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан явуулж мэдлэг,чадвар, дадал хэвшлийг цогцоор нь зохих түвшинд хүргэн цаашид чөлөөтэй хөгжих нөхцөлийг бүрдүүлэх,
- СӨБ-ын үйл ажиллагаанд оролцох эцэг, эх,олон нийтийн идэвхийг нэмэгдүүлэх
- Гадаадын болон дотоодын байгууллагатай харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэг нь Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Дотоод аудитын  чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн  2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус цэцэрлэгийн эрхлэгчийн  2020 оны 18 тоот тушаалаар баталсан ”Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг  мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 154.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 0 | 450.0 | 450.0 |
| Бараа материал | 52,746.2 | 52,610.9 | -135,3 |
| Үндсэн хөрөнгө | 499,732.2 | 653,571.8 | 153,839.6 |
| **Нийт хөрөнгө** | **552,478.4** | **706,632.8** | **154,154.4** |
| Өр төлбөр | 11,259,4 | 22,255,2 | 10,995.8 |

| | | | |
|---|---|---|---|
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 541,218,9 | 684,377,6 | 143,158.7 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **552,478.4** | **706,632.8** | **154,154.4** |

Тайлант онд мөнгөн хөрөнгийн хөрөнгийн үлдэгдэлгүй гарсан ба авлагын данс 0.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ажиллагсадтай холбоотой авлага байна. Бараа материалын данс 0.1 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс 153.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 160.0 сая төгрөгөөр үнэлсэн дуусаагүй барилга, хандиваар авсан 8.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, тооллогоор илэрсэн 0.8 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөрийн данс 10.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Хувь хүний орлогын албан татварын өр 2.5 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн өр 1.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ажилд эргүүлэн томилогдсон ажилтны цалин болох 4.5 сая төгрөгийг шүүхийн шийдвэрээр нөхөн төлсөнтэй холбоотой байна.

Түлш халаалтын өр төлбөр 7.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дулаан, эрчим хүчээр хангадаг " Жанат" ХХК-ийн сарын нэхэмжлэл 2.48 сая төгрөг, жилд 19.8 сая төгрөгийн халаалтын зардлын төлбөрийг нэхэмжилсэнтэй холбоотой ба тус цэцэрлэгийн 1, 2 дугаар салбарын энгийн халаалтын зардалд дунджаар 7.0 сая төгрөгийн зардал гаргасантай холбоотой байна. / 1тн нүүрсний үнэ 40.0-45.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна./

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 143.1 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1181.3 сая, нийт зарлагыг 1181.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 287.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 44.3 сая төгрөгөөр, нормативд зардлыг 115.4 сая төгрөгөөр бууруулж, бараа үйлчилгээний бусад зардлыг 14.5 сая төгрөгөөр нэмэгдэж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийж улсын төсвөөс авах санхүүжилтийг 12.0 сая төгрөгөөр нэмж, орон нутгийн төсвийг 57.6 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 613.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 83.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 696.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 100% зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Эрүүл мэндийг дэмжих | 1,900.0 | 1,900.0 | | 100% |
| 2 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 72,562.5 | 72,562.5 | | 100% |
| 3 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 2,885.8 | 2,885.8 | | 100% |
| 4 | Боловсролын байгууллагын багш, | 1,900.0 | 1,900.0 | | 100% |
| 5 | Боловсролын стандарт, сургалт | 412,023.9 | 412,023.9 | | 100% |
| 6 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 122,300.3 | 122,300.3 | | 100% |
| 7 | Нийтлэг үйлчилгээ | 83,124.5 | 83,124.5 | | 100% |
| | | | | | 100% |
| | **Дүн** | **696,697.0** | **696,697.0** | | 100% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Боловсролын газраас 0.1 сая төгрөгийн санхүүжилт олгож эд хөрөнгө худалдаж авахад зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын сууръ үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 608.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвөөс авсан санхүүжилтийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан, алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 696.6 сая төгрөгийн 12 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 18.7 сая төгрөгийн 2 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж, дүгнэлт гаргуулаагүй, байгууллагын даргын шийдвэрээр  устгал хийгдээгүй 59.7 сая төгрөгийн хөрөнгийг устгал хийх талаар зөвлөмж өгөгдсөнөөс хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 1 | 59.7 | 1 | 59.7 | **100%** |
| **Нийт дүн** | **1** | **59.7** | **1** | **59.7** | **100%** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, гүйцэтгэлийн аудитаар цалингийн зардал болон бусад зардлуудыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3.8 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 3.8 сая төгрөгийн алдааг залруулав.Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гэрэл цахилгааны зардалд илүү тайлагнасан 1.2 сая төгрөгийг залруулж түлш халаалтын зардалд, үр дүнгийн тайлангийн бичиг хэргийн зардалд тусгасан 1.3 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардалд, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд тусгасан 1.2 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд тусгаж залруулга хийв. Нэмэлт санхүүжилтийн 0.1 сая төгрөгийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд оруулан тайлагнасныг залруулж, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгав.

Аудитаар нийт 10.0 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 10.1 сая төгрөгийн зөрчилд нэг албан шаардлага хүргүүлсэн болно.

### 5.1 Төлбөрийн акт

1.Нягтлан бодогч нь албаны ажлаар ажиллах хугацаанд албан томилолт олгох журмыг зөрчиж 258.0 мянган төгрөгийг илүү авсныг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Тайлант онд 27763 хүүхдэд нийтдээ 78,858.0 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан бөгөөд хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормтой харьцуулахад өдөрт 365 төгрөгөөр жилийн дүнгээр 10,144.6 мянган төгрөгийг батлагдсан нормоос хэтрүүлэн зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ҮДТайлангийн бичиг хэргийн зардалд тусгасан 1.3 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардалд, БҮТЭЗ-д тусгасан 1.2 сая төгрөгийг БҮБЗ-д тусгав | 2 | 2534.9 | | | 2 | 2534.9 | 2 | 2534.9 | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гэрэл цахилгааны зардлаас хасаж, түлш халаалтын зардалд тусгав | 1 | 1214.7 | | | 1 | 1214.7 | 1 | 1214.7 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 103.5 мянган төгрөгийг нэмэлт дансанд тусгав | 1 | 103.5 | | | 1 | 103.5 | 1 | 103.5 | | | | |
| **Дүн** | **4** | **3853.1** | | | **4** | **3853.1** | **4** | **3853.1** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хууль тогтоомж зөрчиж илүү албан томилолт | 1 | 258.0 | 1 | 258.0 | | | | | | | | |
| Хоолны зардлын нормын хэтрэлт | 1 | 10,144.6 | | | 1 | 10,144.6 | | | | | | |
| **Дүн** | 2 | **10,402.6** | 1 | 258.0 | 1 | 10,144.6 | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |